



ДААТГАЛ

SINCE 1994

ЖИЛИЙН ТАЙЛАН | 2017

Хүчтэй. Хамтдаа.

## Агуулга

4	ТУЗ-ийн даргын илгээлт
8	Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
11	2017 оны санхүү эдийн засгийн тойм
13	Даатгалын зах зээл
19	Борлуулалт
23	Хүртээмж, салбарын үйл ажиллагаа
25	Нөхөн төлбөр
29	Давхар даатгал
35	Санхүүгийн гүйцэтгэл
41	Групп компаниудын хамтын ажиллагаа
45	Нийгмийн хариуцлага
51	Хүний нөөц
53	Аудитын дүгнэлт



## ТУЗ-ийн даргын илгээлт

Бидэнд итгэл хүлээлгэн, эрсдэлээ даатган, хамтарч ажиллаж буй эрхэм харилцагч, даатгуулагч, хувьцаа эзэмшигч таны энэ өдрийн мэндийг айлтган мэндчилье.

Ард Даатгал ХХК нь 2017 оныг амжилт бүтээлээр дүүрэн үдэж, шинэ ондоо хийж бүтээх хүсэл эрмэлзэл дүүрэн орж байна. Улс орны эдийн засгийн байдал сайнгүй байгаа ч эдийн засаг 2017 онд 5.1 хувийн өсөлттэй гарсан бөгөөд даатгалын салбар ч гэсэн 20-иос дээш хувь өсөн нэмэгдэж, санхүүгийн салбартаа эзлэх хувиа тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн байна. Ард Даатгал ХХК нь Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын багцад томоохон байр суурийг эзлэх бөгөөд групп компаниудтай хамтдаа өсөн дэвжих, хамтран ажиллах, харилцагчиддаа хүргэх санхүүгийн цогц үйлчилгээний нэг чухал хэсэг болох даатгалын үйлчилгээг олон улсын түвшинд хүргэж, эрсдэлийн шийдлийг санал болгон ажиллалаа.

Бид өнгөрсөн жил даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс толгой компани Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран Шангри-Ла дахь салбараас даатгалын бүхий л төрлийн үйлчилгээг авах боломжийг нээн ажиллав. Нийслэл хотын маань хамгийн орчин үеийн, шинэлэг бизнес худалдааны төвд өөрийн үйлчилгээг авах боломжийг нээснээр бидний өрсөлдөх чадвар нэмэгдэж, харилцагчиддаа зөвхөн даатгалын үйлчилгээ аваад зогсохгүй, санхүүгийн бусад үйлчилгээг нэг дороос авах боломжийг олгож байгаа юм.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл өөрийн эзэмших хувийг нэмэгдүүлж хувьцаа эзэмшигч Блю Планет ХХК-иас 10 орчим хувийг худалдан авч, бүртгэлийн ажлыг оны сүүлээр дуусгасан. Блю Планет ХХК-ийн төлөөлөл болох компанийн үүсгэн байгуулагч Ц.Тогтохбаяртаа эрүүл энх, аз жаргалыг хүсэн ерөөж, цаашдын ажил хөдөлмөрт нь амжилт хүсэн ерөөе. Мөн оны сүүлчээр хувьцаа эзэмшигч Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-аас Ард Даатгалын 2 хувийг худалдаж авах хэлцлийг амжилттай дуусгаж, бүртгэлийн ажлыг дуусгасан. Эдгээр хэлцлүүдийн үр дүнд Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Ард Даатгал ХХК-ийн 95 хувийг эзэмших болж, тус компани нь манай хөрөнгө оруулалтын багцад 24 орчим хувийг эзлэх болсон.

2017 оны 5 дугаар сард компанийн Гүйцэтгэх захирлаар Галбадрахын Цогбадрахыг томилсон бөгөөд даатгалын салбарт өмнө ажиллаж байсан арвин туршлагатай шинэ захиралдаа цаашдын ажилд нь амжилт хүсье.


2017 оны 11 дүгээр сард хуралдсан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Ард Даатгал ХХК-ийг хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг хувьцаат компани болох чиглэлийг санал нэгтгэйгээр дэмжин баталсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос даатгалын компанийн дүрмийн санг 5.0 тэрбум төгрөгт хүргэх шаардлагыг Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаа гаргаж, олон нийтэд санал болгох, хөрөнгө татан төвлөрүүлэх замаар хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэх удирдлагад өгсөн.

Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Даатгалаар дамжуулан ердийн даатгалын үйлчилгээ үзүүлээд зогсохгүй нэн хэрэгцээтэй байгаа урт хугацааны тэтгэврийн даатгал, амь насны даатгалын үйлчилгээг Монгол улсын нийт иргэдэд далайцтай хүргэх зорилт тавин ажиллаж байна.

2018 он нь манай компанийн хувьд түүхэн жил болно гэдэгт итгэлтэй байна. Төлөвлөсөн ажлуудын ард гарч, Монгол улсын түүхэнд даатгалын салбар дахь анхны нээлттэй хувьцаат компани болохын төлөө бид ажиллах бөгөөд харилцагч, үйлчлүүлэгч, түнш байгууллагууддаа бидэнтэй хамтран даатгалын салбарын нэн шинэ түүхийг бичилцэхийг уриалж байна.

**ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг**







## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Эрхэм харилцагч, даатгуулагч таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Бидэнд итгэл хүлээлгэн, эрсдэлээ даатгуулж, хамтран ажилласан та бүхэндээ 2017 оны ажлын үр дүнгээ тайлагнаж байгаад баяртай байна.

Бидний хувьд 2017 онд төлөвлөсөн зорилтууддаа хүрч, даатгалын салбарт эзлэх компанийн байр суурийг улам бэхжүүлэн, 100 гаруй ажиллагсадтай, 238 даатгалын төлөөлөгчтэй Монгол улсын бүхий л аймаг, сумдад хүрч ажилласан баг хамт олныг бүрдүүлж чадлаа. 2017 онд манай компани нийт 10.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлж, өнгөрсөн оны эцсийн үр дүнгээс 44.4 хувийн өсөлт үзүүлж, харилцагчиддаа 4.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож ажилласан байна.

2017 онд компани маань 1.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд өөрийн хөрөнгийн өгөөж 23.7 хувьтай байна.

Өнгөрсөн жил бид үйлчилгээний чанарт онцгой анхаарч, харилцагчдаа сэтгэл ханамжтай байлгахыг хичээн ажилласан. Нөхөн төлбөрийг энгийн үед дунджаар ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэж байгаа бөгөөд шинэ жил, цагаан сарын баяр ёслолын үеэр 500 мянга хүртэлх дүнтэй нөхөн төлбөрийг өдөрт нь шийдэж, шуурхай үйлчилж, харилцагчдын талархлыг хүлээлээ.

Бид харилцагчиддаа шинээр газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгож, чамгүй борлуулалт хийлээ. Ургац алдсан аж ахуйн нэгжүүдэд Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал компанитай хамтран 211 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. Мөн тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнийг хялбаршуулан, хүртээмжтэй болгох үүднээс оны эцсээр Хүлэг нэртэй бүтээгдэхүүнийг харилцагчиддаа санал болгож эхэллээ.

Ард Даатгал 2017 онд татварт нийтдээ 316 гаруй сая төгрөг, нийгмийн даатгалд 245 сая төгрөгийг төлж, улс эх орон, ажиллагсдынхаа өмнө хүлээсэн үүргээ өндөрт өргөн ажиллалаа.

Ирэх жил бид компаниа Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргаж, нээлттэй хувьцаат компани болгох, хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалах ажлыг төлөвлөөд, урам зоригтойгоор ханцуй шамлан орлоо. Та эрсдэлээ бидэнд даатган, манай компаниар үйлчлүүлэхийн зэрэгцээ бидний төлөвлөсөн хувьцаа гаргах ажилд оролцож, даатгалын салбарын тоглогч болохыг уриалж байна. Монгол улсад даатгалын салбар улам өсөн өргөжих боломж дүүрэн байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

**Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах**



## **2017 оны санхүү эдийн засгийн тойм**

2017 онд манай улсын эдийн засгийн өсөлт 5.1 хувийн өсөлттэй гарлаа.

2017 оны эхээр Монгол Улсын Сангийн Яам улс эх оронд тулгараад байгаа эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эдийн засгийг тогтворжуулах чиглэлд онцгой анхаарч, ОУВС-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр тохирлоо.

Энэхүү хөтөлбөр нь 3 жилийн хугацаатай үргэлжлэх ба ОУВС-гаас 440 сая долларын санхүүжилтийг олгох бөгөөд ОУВС болон олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 орчим тэрбум долларын хөнгөлөлттэй санхүүжилтийг төсвийн алдагдал төлбөрийн тэнцлийн зориулалтаар ашиглах тохиролцоонд хүрсэн.

2016 онд эдийн засгийн өсөлт -1.2 хувьтай гарч байсан бол 2017 онд 5.1 хувийн өсөлттэй гарлаа. Энэхүү өсөлтийг салбаруудаар нь авч үзвэл, хөдөө аж ахуй 4.4 хувь, үйлчилгээ 8.5 хувиар өсөв.

Мөн 2017 оны хувьд Монгол Улсын экспортын хэмжээ анх удаа 6.2 тэрбум долларыг давж, гадаад худалдааны тэнцэл 1.9 тэрбум долларын ашигтай гарлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өнгөрсөн онд 1.2 тэрбум долларт, алтны худалдан авалт 20 тоннд тус тус хүрч хандивлагч орнууд болон олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр төлбөрийн тэнцэл нэг тэрбум долларыг давж ашигтай гарлаа. Үүний үр нөлөөгөөр гадаад валютын нөөц 3 тэрбум долларт хүрэв.

Улмаар улсын төсвийн орлого 2017 онд анх удаа таван их наяд төгрөгөөр давж, төсвийн зарлагыг 98 хувьтай санхүүжүүллээ. Өнгөрсөн онд гадаадын хөрөнгө оруулалт хоёр дахин нэмэгдсэн гээд эерэг үзүүлэлттэй жил болов. Нийт дүнгээрээ улсын төсвийн мөнгөн хөрөнгө 1.3 их наяд төгрөгөөр нэмэгдлээ.

Засгийн газраас хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах, хууль тогтоомжийг олон улсынхтай нийцүүлэх зорилгоор татварын хоёр дахь шатны шинэчлэлийг хийхээр шийдвэрлэсэн. Жижиг, дунд бизнесийг дэмжихдээ 50 сая хүртэлх орлогоос 1 хувийн татвар авах, мөн аж ахуйн нэгжийн 25 хувийн орлогын албан татварын 3 тэрбум төгрөгийн босгыг 6 тэрбум төгрөгт хүргэхээр ажиллаж байна.



## **Даатгалын зах зээл**

2017 онд даатгалын зах зээлд дараах тусгай зөвшөөрөл бүхий компаниуд оролцож ажилласан байна.

2017 онд даатгалын зах зээлд дараах тусгай зөвшөөрөл бүхий компаниуд оролцож ажилласан байна.

1. Ердийн даатгалын	15
2. Урт хугацааны даатгалын	1
3. Дотоодын давхар даатгалын	1
4. Даатгалын зуучлалын	40
5. Даатгалын хохирол үнэлэгч	31

### **Даатгалын хураамж**

2017 онд даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулсан 15 ердийн даатгалын компани нийт 141.18 тэрбум төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.4 хувийн өсөлттэй байна.

Нийт хураамжийн орлогын 32.41 хувь буюу 45.76 тэрбум төгрөгийг гадаадын давхар даатгалын компанид шилжүүлсэн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өссөн байна.

Цэвэр хураамжийн хэмжээ 91.15 тэрбум төгрөг болж өмнөх оноос 27.2 хувиар өссөн нь нийт даатгалын зах зээл өсч байгааг харуулж байна.

### **Нөхөн төлбөр**

Тайлант улиралд нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оноос 32.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хохирлын харьцаа нийт хураамжийн орлоготой харьцуулахад 31.4 хувь, цэвэр хураамжийн орлоготой харьцуулахад 48.6 хувьтай байна.

### **Нийт хөрөнгө, нөөц сан**

Тайлант хугацаанд даатгалын компаниудын нийт хөрөнгө 193.58 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өссөн байна. Үүний 50.2 хувь буюу 97.20 тэрбум төгрөг нь даатгалын компанийн нөөц сан бол 31.2 хувь буюу 60.33 тэрбум төгрөг нь даатгалын компанийн дүрмийн сан бүрдүүлж байна.


сая төгрөг

№	Санхүүгийн үзүүлэлтүүд	2015	2016	2017
1	Нийт хураамжийн орлого	112,213.3	111,676.5	141,180.4
2	Давхар даатгал	41,932.7	37,122.5	45,762.9
3	Цэвэр хураамжийн орлого	68,059.2	71,662.5	91,151.3
4	Нөхөн төлбөр	35,417.8	33,388.5	44,333.0
5	Ашигт ажиллагаа	4,597.0	8,455.3	8,701.3
6	Нийт хөрөнгө	139,510.2	165,856.9	193,580.1
7	Нөөц сан	63,768.0	78,756.6	97,204.1


сая төгрөг

№	Санхүүгийн үзүүлэлтүүд	Өөрчлөлт (НХО)			
		2015/2016	2016/2017		
1	Нийт хураамжийн орлого	(536.79)	-0.5%	29,503.86	26.4%
2	Давхар даатгал	(4,810.13)	-11.5%	8,640.33	23.3%
3	Цэвэр хураамжийн орлого	3,603.27	5.3%	19,488.82	27.2%
4	Нөхөн төлбөр	(2,029.25)	-5.7%	10,944.52	32.8%
5	Ашигт ажиллагаа	3,858.33	83.9%	245.97	2.9%
6	Нийт хөрөнгө	26,346.68	18.9%	27,723.23	16.7%
7	Нөөц сан	14,988.61	23.5%	18,447.51	23.4%

сая төгрөг




сая төгрөг






сая төгрөг



сая төгрөг



## Малын индексжүүлсэн даатгал

Ард Даатгал ХХК нь 2016 оноос Малын индексжүүлсэн даатгал/МИД/-ын борлуулалтанд оролцож эхэлсэн. Энэ хугацаанд давхардсан тоогоор 889 малчин өрхийн 239,0 мянган толгой малыг даатгалд хамруулж, зуд болон байгалийн бусад төрлийн давагдашгүй хүчин зүйлээс хамгаалж ажилласан.


МИД нь нэг малчны хотонд гарсан хохиролд биш, нийт сумын малын төрөл тус бүрийн хорогдлоос хувь тооцож нөхөн төлбөр олгодог онцлогтой даатгал юм.

2016 оны МИД-ын борлуулалтаар Ард Даатгал нь хамтын эрсдэлийн санд 17.6 сая төгрөг байршуулсан бөгөөд 2017 оны эхний хагас жилд гарсан даатгалын тохиолдолд 3.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.


2017 онд МИД-ын нийт борлуулалтанд эзлэх хувиа 3 хувиар өсгөж ажиллалаа.

Цаашид МИД-ын борлуулалтын улиралд салбар, төлөөлөгчдийг улам идэвхжүүлж, борлуулалтыг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

### 2016-2017 оны борлуулалт (сая төгрөг)



### 2016-2017 оны борлуулалт (сая төгрөг)





## **Борлуулалт**

Даатгалын газар нь 2017 онд нийт 10.3 гаруй тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүллээ.

Даатгалын салбарын өрсөлдөөн ширүүсч, нэгж хураамжийн хувь хэмжээ жил ирэх тусам буурч байгаа зэрэг хүндрэлүүд борлуулалт хийхэд тулгарч байгаа боловч манай компани хөгжингүй орнуудын жишгийг даган шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг цаг алдалгүй зах зээлд нэвтрүүлж, үнийн болон үйлчилгээний уян хатан бодлогыг баримталж, хот орон нутгийн даатгалын менежер, борлуулалтын баг хамт олон 2017 онд амжилттай сайн ажилласнаа тайлагнаж байна.

Даатгалын газар нь 2017 онд нийт 10.3 гаруй тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлж өмнөх оны гүйцэтгэлийг 44.4 хувиар давсан үзүүлэлтийг үзүүллээ. Энэ нь даатгалын салбарын 9 орчим хувьтай тэнцэх үзүүлэлт бөгөөд компанийн зах зээлд эзлэх хувь ч тодорхой хэмжээнд дээшилж, байр суурь бэхжиж байгаагийн илрэл билээ.

Жил ирэх тусам даатгалын компаниудын өрсөлдөх арга барил хурдацтай өсөж байгаа энэ үед байгууллагын борлуулалтын албанаас цөөнгүй тендерт шалгарч даатгалын гэрээг байгуулан борлуулалт хийж чадсан нь томоохон амжилт байсан. Иргэдийн борлуулалтын албанаас олон улсын жишгийг даган банкшуранс буюу банкны зуучлал, зуучлагч брокерийн байгууллагуудтай хамтран ажиллаж, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх ажлыг идэвхтэй хийж байгаа бөгөөд үүний хүрээнд Төрийн банк, Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Капитрон банк, Үндэсний Хөрөнгө Оруулалтын банк зэрэг монголын томоохон банкуудаар дамжуулан даатгалын үйлчилгээг үзүүлж, 12 даатгалын зуучлагч нартай хамтран ажилласан бөгөөд 2017 онд зуучлагчдаар дамжуулан 1.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүллээ.

Даатгалын зуучлалаар хамтран ажиллаж байгаа арилжааны банкууд нь зээлийн болон барьцаа хөрөнгийн даатгалыг түлхүү хийж байгаа бөгөөд хөдөө орон нутагт малын эрсдэлийн даатгалыг мөн идэвхтэй хийсэн байна. Даатгалын зуучлал үзүүлж байгаа компаниуд Улаанбаатар хот, алслагдсан дүүрэг, автомашин оношилгооны цэг болон худалдааны төвүүд дээр төвлөрөн Ард Даатгалын борлуулалтыг хийж байна. Дээрхээс гадна бид банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний хүрээнд даатгалын борлуулалтыг идэвхтэй хийсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулбал борлуулалт 172 хувиар нэмэгдсэн байна.

Харилцагчдыг ангилж үзвэл Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас шалгаруулдаг шилдэг 100 компаниас 70 гаруй компанитай бид даатгалын үйлчилгээгээр хамтран ажиллаж байна. Мөн манай харилцагчдын 17 хувь нь төрийн байгууллагууд байдаг. Тухайлбал Монгол орны хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа Оюу Толгой, Эрдэнэс Таван Толгой, Хөшигтийн Хөндийн олон улсын нисэх онгоцны буудал зэрэг томоохон төслүүд, Энержи Ресурс, Монцемент, Шангри-Ла зэрэг ААН, байгууллага болон Сэргээгдэх эрчим хүч, Уул уурхай, Зам тээврийн салбаруудтай бид хамтран ажилласныг дурдахад таатай байна.

Томоохон байгууллагын харилцагчдад даатгалын газрын зүгээс эрсдэлийн үнэлгээ, даатгал болон нөхөн төлбөрийн холбогдолтой сургалт, танилцуулга хийж харилцагчийг халамжлах арга хэмжээнд нийт 300 гаруй сая төгрөг зарцууллаа.

Манай багцын 40 гаруй хувийг хөрөнгийн даатгал эзэлж байгаа бөгөөд Жолоочийн болон бусад хариуцлагын даатгал 22 орчим хувийг эзэлж байна.

Иргэдийн нийтлэг хийлгэдэг Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зах зээлд бид 15 компаниас 8 дугаарт жагсаж байгаа бөгөөд 2017 онд 1.7 тэрбум төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн байна. Даатгалын ач холбогдлыг ард иргэдэд ойлгуулан таниулахад энэхүү бүтээгдэхүүний үүрэг маш их бөгөөд Монголын Даатгагчдын Холбоогоор дамжуулан албан журмын даатгалын нэр төрлийг олшруулах, даатгалын зах зээлийг тэлэх чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөд байна.





## **Хүртээмж, салбарын үйл ажиллагаа**

Орон нутгийн салбарууд маань нийт 1.4 тэрбум төгрөгийн төлөвлөгөөт даатгалын хураамжийн орлогыг бүрдүүлж, 230 сая төгрөгийн нөхөн төлбөрийг шийдвэрлэсэн байна.

Ард Даатгал ХХК аймаг, орон нутгийн даатгуулагч нартаа өөрийн 21 салбар, сумдад байрлах 105 төлөөлөгч болон зуучлагч банкны салбаруудаар үйлчилж, нийт 1.4 тэрбум төгрөгийн төлөвлөгөөт даатгалын хураамжийн орлогыг бүрдүүлж, 230 сая төгрөгийн нөхөн төлбөрийг шийдвэрлэсэн байна.


Санхүүгийн зохицуулах хорооноос аймгийн салбаруудад хийсэн хяналт шалгалтаар холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгалын үйл ажиллагаа хэвийн эрхэлж байгааг батлан тогтоолоо.

Орон нутгийн байгууллага, ААН-үүдэд хандсан даатгалын зөвлөгөө, сургалтын давтамжаа өмнөх жилээс нэмэгдүүлж, тэдгээрийн даатгалын хэрэгцээ, санхүүгийн чадварт нь тохируулсан уян хатан үнийн бодлого баримтлан ажиллалаа. Үүний үр дүнд даатгуулагч байгууллагын тоо өсч, сургалтын захиалга, хамтран ажиллах санал нэмэгдэж байна.

Иргэдэд хүрч үйлчлэх борлуулалт, мэдээллийн сувгуудыг өргөжүүлэхээр орон нутгийн 60 гаруй Хадгаламж Зээлийн Хоршоодыг нэгтгэсэн Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоо, 330 суманд салбартай Монгол Шуудан ХК-тай стратегийн түншлэлийг бий болголоо.

Компани ажилтнуудынхаа мэргэжлийн мэдлэг, ур чадварт анхаарч танхимын болон зайн сургалтуудыг хийснээс гадна шинээр онлайн мэдээлэл-сургалтын сан, видео хичээлээр хангалаа.

Бид салбаруудынхаа байршлыг даатгуулагч нартаа илүү ойртуулах зорилгоор 11 салбарын байршлыг өөрчилж, тохижуулан сайжрууллаа.








## **Нөхөн төлбөр**

Ард Даатгал нь 2017 онд нийт 3,409 даатгуулагчдад 4.06 тэрбум төгрөгийн хохирлыг төлж барагдуулан, даатгалын гэрээний үүргээ нэр төртэйгээр биелүүллээ.

Бид 2017 онд нийт 3,409 даатгуулагчдад 4.06 тэрбум төгрөгийн хохирлыг төлж барагдуулан, даатгалын гэрээний үүргээ нэр төртэйгээр биелүүллээ. **2017 онд** нийт олгосон нөхөн төлбөрийг өмнөх онтой харьцуулбал 57 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд нийт нөхөн төлбөрийн 38 хувь буюу 1.53 тэрбум төгрөгийг давхар даатгалаас олгосон нь энэхүү өсөлтөнд голлох нөлөө үзүүлжээ.

Даатгалын салбарын хэмжээнд дундаж хохирол төлөлтийн харьцаа 31.4 хувь байсан бол Ард Даатгал компанийн хувьд нөхөн төлбөрийн цэвэр зардлын хувьд 24.5 хувь, нийт нөхөн төлбөртэй харьцуулахад 39.2 хувь байна. Энэхүү үзүүлэлт нь бид эрсдэлээ сайн тараан байршуулж, харилцагчиддаа давхар даатгалын нөхөн төлбөрийг амжилттай хүргэж, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлж буйг илтгэж байна.




Ард Даатгалын ослын дуудлагын шуурхай алба даатгуулагчиддаа 365 хоногт 24 цагийн үйлчилгээ үзүүлж байна. Тайлант хугацаанд бид 500 мянган төгрөг хүртэлх нөхөн төлбөрийг ажлын 3 өдөрт багтаан шийдвэрлэдэг боллоо. Цаашид даатгуулагчдын цагийг хэмнэн интернет орчинд ашиглах боломжтой нөхөн төлбөрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх цахим программ үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

### БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БҮТЦЭЭР НӨХӨН ТӨЛБӨРИЙГ АНГИЛБАЛ



### БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БҮТЦЭЭР ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙГ АНГИЛБАЛ



2017 онд даатгалын болон давхар даатгалын нөхөн төлбөрийн дийлэнх хувь нь барилга угсралтын даатгалаар гарсан ба уул уурхайн салбараас гадна барилга угсралт, инженерингийн салбар хурдацтай хөгжиж буйн илэрхийлэл болж байна.





## **Давхар даатгал**

Давхар даатгалтай бүтээгдэхүүний хураамжийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдэж 2.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2017 онд Монгол Улсын даатгалын болон давхар даатгалын зах зээлд байгалийн болон үйлдвэрлэлийн гаралтай хохирол хэд хэдэн удаа гарсны зэрэгцээ даатгалын хураамжийн хувийн тогтмол уналт нь даатгалын зах зээлд бэрхшээл хүндрэл учруулж байна. Гэвч эдгээр сөрөг нөхцөл байдлыг үл харгалзан он удаан жилийн турш үргэлжилсэн бат бэх харилцаа, түншлэл, хамтын ажиллагаа, салбарын туршлага болон андеррайтингийн хүчинд Ард Даатгал ХХК нь 2017 оныг амжилттай даван туулж, даатгалын салбар дахь өөрийн нэр хүндээ өндөрт өргөн, даатгуулагчийн итгэлийг хүлээн, харилцагчиддаа даатгалын үйлчилгээний ач холбогдлыг бүрэн таниулж ажилласан.

Бид харилцагчдынхаа үйл ажиллагааны чиглэлээс хамаарч давхар даатгалтай бүтээгдэхүүний багцаа төрөлжүүлэхэд чиглэсэн стратегийг хэрэгжүүлэн, шинэ бизнесийн боломжуудыг нээн илрүүлж, давхар даатгагч нартай хийсэн стратегийн түншлэлийн туслалцаатайгаар шинэ зах зээл рүү нэвтрэх аргачлал туршлага хуримтлуулан амжилтаа бататган ажилласаар байна. Үүний үр дүнд давхар даатгалтай бүтээгдэхүүний хураамжийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдэж 2.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Ард Даатгал ХХК нь гадаадын давхар даатгалын компаниудтай идэвхтэй хамтран ажиллахын зэрэгцээ дотоодын давхар даатгагч Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК-тай хамтран Монгол улсын газар тариалангийн даатгалыг анх удаа амжилттайгаар хэрэгжүүлж дөрвөн аж ахуйн нэгжид 211 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Бид малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээг мөн ХААДД компанитай хамтран өөрийн салбаруудаар дамжуулан малчдад хүргэж байна.


Компанийн нэр	A.M. Best Rating	A.M. Best Outlook	Standard & Poor's Rating	Standard & Poor's Outlook
Hannover Rück SE	A+	stable	AA-	stable

Бид Монгол улсын даатгалын зах зээлд эрсдэлийн менежментийг нэвтрүүлж, Трити гэрээгээр эрсдэл даах чадамжаа өсгөж, түргэн шуурхай үйлчилгээгээр хангаж ирсэн билээ. Трити гэрээний давхар даатгагч нь дэлхийн тэргүүлэх давхар даатгалын Hannover Re компани юм. Уг гэрээ нь манай эрсдэл даах чадвхийг нэмэгдүүлэхээс гадна харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт болдог билээ.

Трити гэрээний хүрээнд Ард Даатгал компанийн хөрөнгө, барилга угсралт, тоног төхөөрөмж угсралт, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, тээвэрлэгчийн хариуцлага, олон нийтийн өмнө хүлээх хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, ачаа тээвэр, хүнс машин механизм зэрэг бүтээгдэхүүнийг давхар даатгалд хамрууллаа.

### 2017 оны давхар даатгалын хураамжийн орлогын бүтэц

Давхар даатгалтай бүтээгдэхүүний хураамжийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдэж 2.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.







## Олон улсын эрүүл мэндийн даатгал

Ard Medicare нь Ард Даатгал ХХК-ийн зүгээс үзүүлж байгаа өндөр түвшний эрүүл мэндийн даатгал бөгөөд энэ бүтээгдэхүүний давхар даатгагчаар Hannover Re, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч компаниар MSH International хамтран ажиллаж, харилцагчиддаа санал болгож байна. Энэхүү даатгалаар дотоодын хамгийн чанартай эмнэлгүүд болон гадаадын 200 орны 330,000 гаруй эмнэлгүүдээр үйлчлүүлэх боломжтой.

Ard Medicare нь шаардлагатай эмнэлгийн зардлыг бүрэн хамгаална. Үүнд хэвтэн эмчлүүлэх, амбулатори эмчилгээ, яаралтай нүүлгэн шилжүүлэлт, мэдрэлийн хамгаалалт зэрэг багтсан. Мөн нэмэлтээр жирэмслэлт, эрүүл мэндийн үзлэг болон шүдний хамгаалалт авч болно.

Бид International SOS байгууллагатай хамтран даатгуулагчийн шаардлагатай үед агаараар болон газраар хамгийн ойр байрших эмнэлэгт хүргэж, хамгийн чанартай эмнэлгийн үйлчилгээ үзүүлнэ. Энэхүү хамгаалалтад асран хамгаалагчийн онгоцны тийз болон зочид буудлын зардлыг бүрэн хариуцах юм.

Манай харилцагчид дэлхийн хаа ч байсан цогц эрүүл мэндийн үйлчилгээг “MSH International”-ийн Францын Парис, Канадын Калгари, Арабын Нэгдсэн улсын Дубай, Хятадын Шанхай хотод орших 4 төв оффисоор дамжуулан авах боломжтойгоос гадна үйлчлүүлэгчиддээ эрүүл мэндийн зөвлөгөөг 24 цагаар жилийн 365 хоногийн турш үзүүлнэ.

MSH нь 2008 болон 2011 онуудад ISO 2001 стандартыг хангасан байгууллага болсон ба 2013 оны 8 сард ISO 27001 стандартыг авсан. Энэ стандартыг хэрэгжүүлснээр MSH нь үйлчлүүлэгчийн мэдээллийг чандлан нууцалж, бусдад дамжуулах, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэй бөгөөд энэхүү стандартыг хангасан анхны даатгалын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг компани болсон.

Бид даатгуулагч нартаа 194 улсад MSH-ийн 2,000 салбар нэгж, 330,000 гаруй эмнэлэгээр үйлчлүүлэгч өөрөөсөө төлбөр төлөхгүйгээр, шууд төлбөрийн картаар (Direct Billing Card) үйлчлүүлэх боломжийг олгодоггоороо бидний үйлчилгээнд үнэ цэнэ нэмж байгаа.

**MSH-ийн аппийг татаж авахыг хүсвэл:**

1. App Store болон Play Store дээр “MSH Service” гэж хайж, гар утасны апп татах боломжтой.
2. Мөн Wechat болон QR Code Scanner ашиглан татах боломжтой.







## Санхүүгийн гүйцэтгэл

Ард Даатгал ХХК-ийн нийт актив 23 хувиар өсч 11.73 тэрбум төгрөгт хүрсэн байна.



2017 оны хувьд улс төрийн тогтворгүй байдал, он дамжсан эдийн засгийн таагүй нөхцөл байдал үргэлжилсэн хүнд жил байсан ч өнгөрсөн жилүүдэд алдсан зах зээл дэх байр суурь, хураамжийн орлогыг нэмэгдүүлэн, харилцагч, даатгуулагчид, хувьцаа эзэмшигчдийн итгэлийг хүлээсэн, санхүүгийн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдээс хүчирхэгжүүлсэн амжилттай жил байлаа.

Ард Даатгал ХХК-ийн нийт актив 23 хувиар өсч 11.73 тэрбум төгрөгт хүрч, нөөц сан 28 хувиар өсч, 5.56 тэрбум төгрөгт хүрсэн байна.




Хураамжийн орлого 10.36 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 44.4 хувиар өссөн хэдий ч өнгөрсөн онтой харьцуулахад агаарын хөлгийн даатгал, хариуцлагын даатгал, ачаа тээврийн даатгалууд буурсан байна.

Хөрөнгө оруулалтын орлого 75 хувиар өсч, 1.4 тэрбум төгрөгт хүрсэн ба тус орлого нь банкны хадгаламжийн хүү, үнэт цаасны арилжааны өгөөж, үнэлгээ, бусад хөрөнгө оруулалтуудын өгөөжөөс бүрдэж байгаа бөгөөд 1.12 тэрбум төгрөгийн ашигт ажиллагаанд томоохон нөлөө үзүүлсэн байна. 2017 онд банкны хадгаламж, засгийн газрын үнэт цаас, хөрөнгийн бирж дэх хувьцааны арилжаа зэрэгт хөрөнгө оруулахаас гадна үл хөдлөх хөрөнгийн арилжаа, компанийн бондууд зэрэг өгөөж өндөртэй арилжаануудад оролцож ашигтай ажиллаж чадлаа.





Тус тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааны зардал 3.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 0.4 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд сүүлийн 3 жилд үйл ажиллагааны зардлыг 3.8 тэрбум төгрөгт барьж, зардлын хяналтыг сайжруулж компанийн үр өгөөжийг дээшлүүлсээр ирлээ.



	Харьцаа үзүүлэлт	2014	2015	2016	2017
1	Хохирлын харьцаа (НХО)	30.6%	41.8%	36.2%	39.2%
2	Хохирлын харьцаа (ЦХО)	37.8%	54.1%	45.6%	58.8%
3	Хохирлын харьцаа (ОТХ)	40.7%	58.9%	44.4%	67.4%
4	Хөрөнгө оруулалтын орлогын дундаж өгөөж	18.1%	13.9%	27.2%	40.5%
5	Зардлын харьцаа (НХО)	43.1%	42.1%	53.1%	36.6%
6	Зардлын харьцаа (ЦХО)	53.2%	54.4%	66.9%	54.9%
7	Зардлын харьцаа (ОТХ)	57.4%	59.3%	65.2%	62.9%
8	Хосолсон харьцаа (НХО)	73.8%	83.9%	89.3%	75.9%
9	Хосолсон харьцаа (ЦХО)	91.0%	108.5%	112.5%	113.7%
10	Хосолсон харьцаа (ОТХ)	98.1%	118.1%	109.6%	130.3%
11	Хөрөнгийн өгөөж	6.8%	-1.6%	4.7%	10.6%
12	Өөрийн хөрөнгийн өгөөж	12.9%	-3.4%	10.7%	23.7%

Даатгалын компанийн үйл ажиллагааны чанарын үзүүлэлтийг дээрхи харьцаа үзүүлэлтээс дүгнэж болно.

Харьцаа үзүүлэлтүүдийн хувьд жилээс жилд эерэг үзүүлэлтэй болж компанийн үр ашигт байдал нэмэгдсээр байна. Хохирлын харьцаа 2016 оноос өссөн харагдаж байгаа ч нийт олгосон нөхөн төлбөрийн 1.5 тэрбум төгрөг нь давхар даатгалаас төлөгдсөн бөгөөд даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр нь 2.5 тэрбум төгрөг буюу компанийн хариуцаж төлсөн нөхөн төлбөрийн харьцаа 0.24 гарсан байна.

Зардлын харьцаа 0.37 гарч өмнөх жилүүдээс харьцангуй буурсан ба өөрөөр хэлбэл компани нэг төгрөгийн орлого олоход 0.37 төгрөгийн зардал гаргаж байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулбал зардал багатай ажилласан байна.

Нийт хөрөнгийн өгөөж 10.6 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 23.7 хувьд хүрч сүүлийн 4 жилд гараагүй өндөр үзүүлэлттэй гарчээ.

## Газар тариалангийн даатгал

Монгол улсын газар тариалангийн нийт бүтээгдэхүүний 60 хувийг дангаар эзэлж буй улаан буудайг туршилтын журмаар 2016 оноос Сэлэнгэ болон Төв аймгийн зарим сумдад даатгасан бөгөөд 2017 онд орон нутгийг бүхэлд нь хамруулан борлуулалт хийлээ. Ард Даатгал ХХК нь газар тариалангийн даатгал хийх зөвшөөрөл авсан анхны компани юм.

Нэрлэсэн эрсдэлд улаан буудай тариалж буй тариаланчдыг байгаль, цаг уурын болон бусад урьдчилан сэргийлэх боломжгүй нэр бүхий эрсдэлээс шалтгаалан ургац алдах, улмаар эдийн засгийн хохирол хүлээх эрсдэлээс хамгаалах зорилготой бөгөөд ган, мөндөр, аянга цахилгаан, цочир хүйтрэлт, гал, хүчтэй салхи, шороон шуурга, үргэлжилсэн бороо, үер, мөн нэмэлт эрсдэлд мал идэх, талхлах зэрэг тохиолдлуудыг даатгалын эрсдэлд хамруулсан. Тухайн даатгагч даатгуулагч харилцан тохиролцож үнээ гаргах бөгөөд ойролцоогоор 1 тонн улаан буудайг 550,000 төгрөгөөр даатгах ба даатгалын хураамж нь эрсдэлийн түвшнээс шалтгаалан 4-12 хувь байна. Тухайн даатгуулагчийн сүүлийн 5 жилийн дундаж ургацын хэмжээг тооцоолон даатгах бөгөөд даатгуулагч 40 болон 50 хувийн өөрийн хүлээх хариуцлагын түвшнээс сонголт хийж даатгуулна. Өөрөөр хэлбэл даатгуулагчид учирсан эрсдэлийн 50 болон 60 хувь хүртэлх эрсдэлийг даатгагч хариуцах юм. Тухайн даатгуулагчийн дундаж ургац алдалтыг тооцоолон нөхөн төлбөрийг олгодог байна.

2017 онд Ард Даатгал нь Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал болон SCOR RE олон улсын давхар даатгалын компаниудтай хамтран Дарханы газар тариалангийн хүрээлэнгээс үр авсан 9 аж ахуйн нэгжийн 5 аймаг дамнасан, 817.07 га талбайг даатгасан нь Ард Даатгал компанийн хийж байгаа анхны газар тариалангийн даатгал болж байгаагаараа онцлогтой юм.

Өнгөрсөн хавар бид газар тариалангийн даатгалаар 985 сая төгрөгийн үнэлгээтэй нийт 817.07 га талбайг даатгаж, 46 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлж, тариалалтын үе өнгөрснөөс хойш дээрх даатгалын гэрээг дүгнэн, 4 аж ахуйн нэгжид 211 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.





## **Групп компаниудын хамтын ажиллагаа**

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн харъяанд Монгол Шуудан ХК, Ард Даатгал ХХК, Ард Кредит ХХК, Ард Секюритиз ҮЦК ХХК, Ард Лайф ХХК, Ард Менежмент ХХК, Ард Актив ХЗХ, ТэнГэр Системс ХХК зэрэг компаниуд үйл ажиллагаа идэвхтэй явуулж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн харъяанд Монгол Шуудан ХК, Ард Даатгал ХХК, Ард Кредит ХХК, Ард Секюритиз ҮЦК ХХК, Ард Лайф ХХК, Ард Менежмент ХХК, Ард Актив ХЗХ, Тэнгэр Системс ХХК зэрэг компаниуд үйл ажиллагаа идэвхтэй явуулж байна.

[Ард Даатгал ХХК](#) нь группын дор үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай идэвхтэй хамтарч ажиллахын зэрэгцээ даатгалаас гадна санхүүгийн бусад үйлчилгээ, үйл ажиллагааг санал болгож, харилцагчиддаа хүргэж байна.

[Бид Монгол Шуудан ХК](#)-тай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр даатгалын борлуулалтыг 2016 онд эхэлж, 2017 онд даатгалын зуучлалын ажлыг эрчимжүүлж нийт 83 сая төгрөгийн борлуулалтыг хийгээд байна. Мөн Ард Даатгал компанийн хөдөө орон нутгийн салбарууд Монгол Шуудан ХК-ийн эзэмшлийн байранд байр түрээслэн хамтын ажиллагаагаа улам ойртуулсан. Монгол Шуудан ХХК-ийн аймаг, сумдад ажиллаж байгаа ажилтнуудад даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар бүрэн хэмжээний сургалтыг хийж, төлөөлөгчдийг албажуулах, цаашилбал Монгол Шуудан ХК нь даатгалын зуучийн зөвшөөрөл авах ажилд бидний зүгээс туслан дэмжиж ажиллах болно.

[Ард Кредит ББСБ ХХК](#)-ийн ажиллагсад нь мөн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг өөрийн харилцагчдад санал болгож ажилладаг. 2017 онд нийт 37.3 сая төгрөгийн даатгалын борлуулалтыг хийж хамтарч ажилласан бөгөөд Ард Кредит ХХК-ийн зээлийн эрсдлийн даатгал, кредит картын болон картын үлдэгдлийн эрсдлийн даатгалыг ирэх жилээс нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ард Даатгал ХХК-ийн өмчлөлд байсан үл хөдлөх хөрөнгийг борлуулахад Ард Кредит ХХК-ийн ажиллагсад идэвхтэй ажиллаж, харилцагчийг олж санхүүжилтийг олгон амжилттай хамтарч ажиллалаа.

[Ард Секюритиз ҮЦК ХХК](#) нь брокер дилер, андеррайтерийн тусгай зөвшөөрөл бүхий компани бөгөөд өөрийн үйлчилгээг хөдөө орон нутгийн харилцагчдад хүргэхдээ Ард Даатгал ХХК-ийн салбаруудыг түшиглэн ажиллаж, үнэт цаасны данс нээх, үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгөх, үнэт цаас болон зах зээлийн талаар зөвлөгөө мэдээлэл авах зэрэг хялбар, нэн тэргүүний үйлчилгээг Ард Даатгал компанийн салбаруудад хандан авч байна.

[Ард Лайф ХХК](#) нь Хас банкинд 2007 оноос хойш туршигдсан тэтгэврийн сангийн үргэлжлэл бөгөөд үйл ажиллагаагаа 2014 онд Ард Актив ХЗХ дээр сэргээж, 2016 онд тусдаа бие даасан компани болон өргөжиж, өнөөг хүртэл амжилттай ажиллаж буй анхны хувийн тэтгэврийн сан юм. Хувийн тэтгэврийн сангийн хууль одоогийн байдлаар батлагдаагүй ч энэхүү үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэж, цаашид улам ирээдүйтэй байж чадна гэдгийг энэхүү богино хугацаанд бид хангалттай нотолж чадлаа. Ард Лайф ХХК нь цаашид амьдралын даатгалын үйлчилгээг үзүүлнэ. 2016 оноос Ард Даатгал ХХК-тай хамтран тэтгэврийн хуримтлалын үйлчилгээг гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнтэй хослуулан, тэтгэврийн дансны үйлчилгээ авч буй харицлагчиддаа санал болгож байна.

[Ард Менежмент ХХК](#) нь хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн зөвлөх компани бөгөөд 2017 оноос Ард Даатгал ХХК-тай хамтын ажиллагааг үр бүтээлтэй эхлүүллээ. Ард Даатгалын хөрөнгө оруулалтын багцыг удирдах, мөн компани дээр байгаа үл хөдлөх хөрөнгүүдийг удирдах, худалдан борлуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгах, хувьцаа, засгийн газрын бонд, компанийн бонд зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд даатгалын нөөц сангууд, сул эх үүсвэрүүдийг байршуулж, өндөр өгөөж хүртэх боломжийг олгож ажиллалаа. Ард Менежменттэй байгуулсан гэрээний дагуу бид үл хөдлөх хөрөнгийн санд хөрөнгө оруулалт хийх, сүүлийн үед зах зээл дээр маш том боломжуудыг нээж буй цахим мөнгөнд хөрөнгө оруулах, гадаад дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй хувьцаа үнэт цаас худалдан авах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. 2017 онд Ард Даатгалын хэмжээнд хөрөнгө оруулалтын орлогыг 1.4 тэрбум төгрөгт хүргэн ажилласан бөгөөд үүнээс Ард Менежмент компани 27 орчим хувийг хийж, үйлчилгээний хөлс шимтгэлд 9 орчим сая төгрөгийг төлж ажиллалаа.





## **Нийгмийн хариуцлага**

Ард Даатгал ХХК нь компанийн Нийгмийн хариуцлагыг байнга ухамсарлаж, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулан, харилцагч даатгуулагч, хамтрагч түнш байгууллага, олон нийт, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагыг гүн ухамсарлан, бизнесийн өндөр ёс зүй, хэм хэмжээг зарчим болгон улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар нийт хамт олноороо чармайн ажиллаж байна.

Ард Даатгал ХХК нь компанийн Нийгмийн хариуцлагыг байнга ухамсарлаж, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулан, харилцагч даатгуулагч, хамтрагч түнш байгууллага, олон нийт, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагыг гүн ухамсарлан, бизнесийн өндөр ёс зүй, хэм хэмжээг зарчим болгон улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар нийт хамт олноороо чармайн ажиллаж байна. [Компанийн нийгмийн хариуцлага нь](#) хүн, байгаль орчин, баялаг гэсэн үндсэн гурван асуудлыг тэнцвэртэйгээр хангаж байх ёстой.

**Жил бүрийн ахмадын баяр болон “Цагаан сар”-ын** баярыг тохиолдуулан компанийн зүгээс нэгэнтээ Ард Даатгалын хамт олны эгнээнд багтаж, хамтран зүтгэж байсан ахмад ажилтнууддаа гарын бэлгийг хүргүүлж хүндэтгэл үзүүлдэг уламжлалыг тасралтгүй үргэлжлүүлж байна.

**Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг** тохиолдуулан манай хамт олон 29 дүгээр тусгай дунд сургуулийн 1-5 дугаар ангийн 150 сурагчдад бэлэг гардуулж баярлууллаа. Мөн ажиллагсдын санаачлагаар Баянгол дүүргийн хүүхдийн асрах төвд зайлшгүй хэрэгцээтэй хүүхдийн тэрэг, хөлд оруулагч, хүүхдийн бассейн, тоглоом зэргийг бэлэглэж, Сонгинохайрхан дүүргийн гал унтраах ангид мөнгөн тусламж үзүүлэв.

**Жил бүр зохиогддог Улаанбаатар марафон-2017** бүх нийтийн гүйлтэнд хамт олны төлөөлөл маань амжилттай оролцлоо.

**Эрсдэлийн удирдлагын сургалтыг** 2017 онд нийт 100 гаруй байгууллагуудад өөрсдийн даатгалын менежерүүдээр дамжуулан үнэ, төлбөргүй зохион байгууллаа.


**Уламжлалт Чингэлтэй хайрханы хишиг барилдааныг** энэ жил илүү өргөн хүрээнд Ард Санхүүгийн Нэгдэл, Хөрөнгө Оруулагч Үндэстэн компаниудтай хамтран зохион байгуулж, Ард Даатгал ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.


**Бидний түнш Монгол Коосен сургуулийн Моко багт Робокон-2017** тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд тус баг нь тэмцээндээ амжилттай оролцож 4-р байрын шагнал, шилдэг баг өргөмжлөл хүртэж ивээн тэтгэгч биднийг баярлуулсан.

**Дуулиан-2020** хүүхдийн заалны хөлбөмбөгийн тэмцээнд оролцож байгаа Сонгинохайрхан дүүргийн алслагдсан сургуулиуд болох 106, 107 дугаар сургуулийн багийг энэ жил мөн ивээн тэтгэж, тэмцээний хураамж, хөл бөмбөгийн өмсгөл, бөмбөгийг гардууллаа.


**Нийслэлийг нөмөрсөн түймрийн** утаа, галын аюултай тэмцэх үүднээс олон нийтийн сүлжээгээр давалгаалсан тусламжийн хөдөлгөөнд манай компани болон ажиллагсад маань нэгдэж, гал түймэртэй тэмцэх ангийнхан болон сайн дурынханд хоол хүнс болон мөнгөн тусламж үзүүлж, нийгмийн хариуцлагатай байгууллага болохоо батлан харууллаа.

**Монгол Шуудан ХК болон what3words-тэй** хамтран 2017 оны 12 сарын 1-нээс 22-ны хооронд аймаг, хотын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Өвлийн өвгөний шуудан” захидал, шүлэг, гар зургийн уралдаан зохион байгууллаа. Уг уралдаанд нийт 15,000 хүүхэд оролцсоноос 100 бүтээлийг шалгаруулан, бүтээлийн эздэд урамшуулал олгосон. Уралдааны хүрээнд Амгалангийн 27-р сургууль, Сонгинохайрхан дүүргийн 104-р сургууль, Баянгол дүүргийн Монгени цогцолбор сургууль дээр “Захидал гэж юу вэ, хэрхэн бичих вэ?”, “Шуудангийн үүсэл хөгжил”, “Даатгалын тухай ойлголт”, “Нандин эрдэнэ хүүхдийн даатгалын ашиг тус”, “W3W гэж юу вэ?” гэсэн сэдвүүдээр өдөрлөг зохион байгуулж, идэвхтэй оролцсон сурагчдыг гарын бэлгээр урамшууллаа.









## **Хүний нөөц**

Ард Даатгал ХХК нь 20 гаруй жилийн ажлын түүх, туршлагатай даатгалын чадварлаг боловсон хүчнийг олон жилийн турш эгнээндээ нэгтгэн мэргэжлийн ёс зүйтэй, итгэлтэй хамт олон бүрдүүлэн ажиллаж салбартаа тэргүүлсэн, нэр хүндтэй компани болж чадсан билээ.

2017 оны жилийн эцсийн байдлаар компанид 100 орчим ажилтан ажиллаж байгаа бөгөөд даатгалын, эрсдэлийн удирдлагын, санхүү удирдлагын, үйл ажиллагааны газар гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байна. Нийт ажиллагсдын 55 хувь нь хөдөө орон нутгийн салбарт ажиллаж байна. Хүйсийн харьцааны хувьд ажиллагсдын 40 орчим хувь нь эрэгтэй бөгөөд ажилтнуудын дундаж нас 34-41 -ийн хооронд байна.

Компанийн хүний нөөцийн бодлогын хүрээнд нийт ажиллагсдыг эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулж, ажиллах хугацаандаа хуримтлал бий болгох, ажлын байрандаа тогтвортой ажиллах, ажил олгогчийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлэх үүднээс тэтгэврийн хуримтлалын санд 100 хувь хамрууллаа.



Ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг 2017 оноос Ард Санхүүгийн Нэгдлийн зүгээс групп компаниудын хэмжээнд санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд Ард Даатгалын ажиллагсад энгийн хувьцааг урамшуулал хэлбэрээр хуваарилав.

Шинэ оны босгон дээр компанийн хамт олноос ажил хөдөлмөрөөр тэргүүлсэн нөхөн төлбөрийн албаны менежер Б.Батцэцэг, даатгалын менежер Б.Энхжин, Багануур салбарын захирал Т.Баярхүү нар Санхүүгийн зохицуулах хорооны “Хүндэт жуух бичиг”-ээр, Сангийн яамны “Санхүү банкны тэргүүний ажилтан” цол тэмдгээр даатгалын ерөнхий менежер Д.Баттулга, ахлах санхүүч Г.Баярбат, Монголын даатгагчдын холбооноос Оны шилдэг даатгалын менежерээр Б.Янжмаа, Оны шилдэг нөхөн төлбөрийн менежерээр Д.Ариунзул нар тус тус шагнагдлаа.







## **| Аудитын дүгнэлт**

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “АРД ДААТГАЛ” ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

#### Санал дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Ард Даатгал” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Ард Даатгал” ХХК -ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан даатгалын багц дүрмийн дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

#### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Харин бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн

боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.



Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээллэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.



**2018 ОНЫ 03 ДУГААР  
САРЫН 16-НЫ ӨДӨР**

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

сая төгрөг

	12/31/2017	12/31/2016
<b>ХӨРӨНГӨ</b>		
Үндсэн хөрөнгө /цэвэр/	2,039.77	2,173.23
Урьдчилж төлсөн тооцоо/ зардал	1,108.99	591.19
Бараа материал	10.09	32.61
Авлага	1,990.82	1,980.02
Санхүүгийн хөрөнгө	3,123.66	1,823.28
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,453.31	2,940.82
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>11,726.64</b>	<b>9,541.14</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
Нөөц сан	5,559.59	4,355.18
Давхар даатгагчид өгөх өглөг	588.50	609.20
Бусад өглөг	252.44	252.74
Татварын өглөг	16.16	16.40
Татварын бусад өглөг	72.80	65.11
<b>НИЙТ өр төлбөр</b>	<b>6,489.50</b>	<b>5,298.64</b>
<b>Эздийн өмч</b>		
Дүрмийн сан	3,500.00	3,500.00
Хуримтлагдсан ашиг	1,737.14	742.51
Нийт эздийн өмч	5,237.14	4,242.51
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,726.64</b>	<b>9,541.14</b>

## ОРЛОГЫН ТАЙЛАН

сая төгрөг

	12/31/2017	12/31/2016
<b>Нийт хураамжийн орлого</b>	<b>10,355.13</b>	<b>7,172.29</b>
Давхар даатгал	3,301.85	1,346.38
Буцаасан даатгал	141.38	131.93
<b>Цэвэр хураамжийн орлого</b>	<b>6,911.89</b>	<b>5,693.98</b>
<b>Орлогод тооцсон хураамж</b>	<b>6,028.95</b>	<b>5,842.94</b>
Нийт нөхөн төлбөр	4,063.12	2,595.76
Хөрөнгө оруулалтын орлого	1,400.03	801.37
Давхар даатгалын комиссын орлого	128.25	45.64
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>4,745.64</b>	<b>4,154.14</b>
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>3,792.87</b>	<b>3,809.50</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал</b>	<b>952.77</b>	<b>344.64</b>
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал	307.26	144.98
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал</b>	<b>1,260.03</b>	<b>489.62</b>
Орлогын албан татвар	136.06	58.48
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>	<b>1,123.97</b>	<b>431.13</b>

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

сая төгрөг

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
<b>2015 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл</b>	<b>3,500.00</b>	<b>311.37</b>	<b>3,811.37</b>
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)		431.13	431.13
<b>2016 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл</b>	<b>3,500.00</b>	<b>742.51</b>	<b>4,242.51</b>
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)		1,123.97	1,123.97
Зарласан ногдол ашиг		(129.34)	(129.34)
<b>2017 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл</b>	<b>3,500.00</b>	<b>1,737.14</b>	<b>5,237.14</b>

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

сая төгрөг

	12/31/2017	12/31/2016
<b>1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>Татварын өмнөх ашиг, (алдагдал)</b>	<b>1,260.03</b>	<b>489.62</b>
Тохируулга:	-	-
Элэгдэл, хорогдлын зардал	88.69	47.37
Үндсэн хөрөнгө худалдсаны (олз), гарз	(97.84)	13.62
Үндсэн хөрөнгө акталсны гарз	3.76	-
Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн тохируулга	(265.96)	(78.37)
Найдваргүй авлагын зардал	73.03	-
Мөнгөн бус урамшууллын зардал	20.02	-
Бусад орлого	(244.79)	-
<b>Ажлын капиталын өөрчлөлт</b>	<b>-</b>	<b>-</b>
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3 сараас дээш хугацаатай)	(182.15)	17.42
Даатгалын авлагын өөрчлөлт	482.44	(327.67)
Бусад санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт	(221.17)	(325.59)
Бусад санхүүгийн бус хөрөнгийн өөрчлөлт	(90.53)	(21.87)
Даатгалын хөрөнгийн өөрчлөлт	(327.98)	(158.80)
Даатгалын өр төлбөрийн өөрчлөлт	(11.25)	328.07
Бусад санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт	(111.41)	5.20
Санхүүгийн бус өр төлбөрийн өөрчлөлт	51.40	19.41
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	882.94	(148.96)

Учирсан боловч мэдэгдээгүй ХНС-ийн өөрчлөлт	135.86	(262.52)
Мэдсэн боловч төлөгдөөгүй ХНС-ийн өөрчлөлт	21.81	8.02
Учирч болзошгүй ХНС-ийн өөрчлөлт	163.80	227.03
Тусгай нөөц сангийн өөрчлөлт	-	-
Төлсөн орлогын албан татвар	(62.18)	(59.63)
Хүүний орлого	(696.94)	(557.61)
Хүлээн авсан хүү	620.84	534.10
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,492.42</b>	<b>(251.15)</b>
<b>2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(121.17)	(146.02)
Худалдсан үндсэн хөрөнгө	134.46	16.82
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө	(5,333.49)	(2,632.15)
Худалдсан санхүүгийн хөрөнгө	4,335.08	1,011.92
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(935.12)</b>	<b>(1,749.43)</b>
<b>3.САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
Хуваарилсан ногдол ашиг	(129.34)	-
Ханшийн зөрүүний гарз	10.20	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(119.14)</b>	<b>-</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>388.15</b>	<b>(2,000.59)</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>405.15</b>	<b>2,405.74</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>793.31</b>	<b>405.15</b>

# ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ



Ердийн даатгал



Банк бус санхүүгийн  
байгууллага



Брокер, диллер, андеррайтер  
хөрөнгө оруулалтын зөвлөх



Тэтгэврийн сан



Хадгаламж зээлийн  
хоршоо



Хөрөнгө оруулалтын  
менежмент



Хөрөнгө оруулалтын сан



Криптовалютын арилжаа



Санхүүгийн сургалт



Шуудангийн цогц  
шийдэл




Санхүүгийн програм хангамж





Үл хөдлөх хөрөнгийн  
түрээс

Хүчтэй. Хамтдаа.

 [info@arddaatgal.mn](mailto:info@arddaatgal.mn)

 [arddaatgal.mn](http://arddaatgal.mn)

 [цэнэг.эрдэмтэй.өнгөлөх](#)

 7720 0089